



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/587

Мандалговь

Аймгийн "Шилдэг төрийн албан хаагч"  
шалгаруулж, урамшуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан "Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам"-ын 6.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн "Шилдэг төрийн албан хаагч"-аар 1 дүгээр хавсралтад дурьдсан 8 төрийн албан хаагчийг шалгаруулж, тус бүр өргөмжлөл, 1000000 (нэг сая) төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг төрийн албан хаагчийн шагнал, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Шагнал, урамшууллын заралд шаардагдах 8.388.000 (найман сая гурван зуун наян найман мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488010783

Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар  
сарын 25-ний өдрийн 108 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



"ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ"-ААР  
ШАЛГАРСАН АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал
1	Гантулгын Мөнхтуяа	Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
2	Норовын Мөнгөнцэцэг	"Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
3	Нармандахын Ганбат	Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
4	Хавчуурын Анхбаяр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн
5	Эрдэнэчулуун Азжаргал	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга, судалгаа шинжилгээ хариуцсан ерөнхий синоптик инженер
6	Ханддоржийн Цогзолмаа	Боловсрол соёл, урлагийн газрын мэргэжилтэн
7	Уяатын Өнөрбаяр	Төв халхын дуулалт жүжгийн театрын бүжгийн багш
8	Оюунгэрэлийн Буянтогтох	Биеийн тамир, спортын газрын дасгалжуулагч

Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар  
сарын 6-ний өдрийн 100 тоот  
захирамжийн 2 дугаар хавсралт



ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	8	1000000	8 000 000
2	Өргөмжлөл	8	42000	336 000
3	Батламж	8	6500	52 000
	ДҮН			8 388 000